

Тойм ба үндэслэл

<p>Үзүүлэлт</p>	<p>2. СББӨ-ийн хамгаалалт, менежментийг дэмжих боловсон хүчний чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр байдаг эсэх</p>	
<p>Үнэлгээний хүчин зүйлүүд</p>	<p>Энэ үзүүлэлтийг оролцогч талуудаар хянуулж, тайлагнасан үндэсний түвшний гурван хүчин зүйл дээр үндэслэн үнэлдэг:</p>	
	<p>2.1 Дээд боловсролын байгууллагууд нь СББӨ-ийн хамгаалалт, менежментийн чиглэлээр сургалтын хөтөлбөр, эрдмийн зэргийг хүртээмжтэйгээр санал болгох.</p>	<p>Зүйл: 14(a)(iii) OD 107(k)</p>
	<p>2.2 Төрийн байгууллагууд, төв болон бусад байгууллагууд СББӨ-ийн хамгаалалт, менежментийн сургалтыг хүртээмжтэй байдлаар явуулах.</p>	<p>Зүйл: 14(a)(iii)</p>
	<p>2.3 Олон нийтийн эсвэл ТББ-д суурилсан санаачилгууд нь СББӨ-ийн хамгаалалт, менежментийн сургалтыг хүртээмжтэй байдлаар явуулах.</p>	<p>Зүйл: 14(a)(iii)</p>
<p>ТХЗ болон бусад үзүүлэлтийн холбоо хамаарал</p>	<p>Тогтвортой хөгжлийн зорилтууд: Энэ үзүүлэлт нь ТХЗ-н 11.4 “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах, хамгаалах хүчин чармайлтыг бэхжүүлэх” гэсэнтэй бүрэн холбогдож байна. Хэрвээ хөгжиж буй улс өөрийн чадавхыг бэхжүүлэхийн тулд олон улсын туслалцаа дэмжлэг авах нь ТХЗ-н зорилго 17.9 “Хөгжиж буй орнуудад үр дүнтэй, зорилтот чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд олон улсын дэмжлэг үзүүлэх” гэсэнтэй нийцэж байгаа юм. Энэхүү үзүүлэлт нь мөн “Тогтвортой хөгжлийг дэмжих, соёлын тогтвортой хөгжилд оруулсан хувь нэмрийг үнэлэхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг суралцагчдад эзэмшүүлэхэд чиглэсэн” ТХЗ-н 4.7-г дэмжиж байгаа юм.</p> <p>Бусад үзүүлэлтийн холбоо хамаарал: Энэ үзүүлэлт нь дунд сургуулийн дараах түвшинд СББӨ-ийн хамгаалалт, менежментийн чиглэлээр мэргэшсэн сургалт мөн эрдмийн зэргийн бус богино хугацааны сургалт зэрэг олон төрлийн боломжууд байгаа эсэх дээр анхаарлаа хандуулах. Үзүүлэлт-3 сургалтын хөтөлбөр ба түүний үр нөлөөг суралцагчдад чиглүүлдэг. Харин үзүүлэлт-4,5 болон 6 нь бага, дунд, дунд боловсролын дараах түвшинд хэрэгжих хөтөлбөр нь ихэвчлэн СББӨ-ийг хамгаалах менежментэд чиглэгдэхгүй, харин түүнийг хэрэгжүүлэх, дамжуулах, мөн илүү хүндэтгэн үзэхийг дэмжихэд чиглэгддэг.</p>	
<p>Үйл ажиллагааны үндэслэл</p>	<p>СББӨ-ийг хамгаалах чадавхыг бэхжүүлэх нь тухайн улс СББӨ-ийг хамгаалах чиглэлээр урт хугацааны туршлагатай байх эсвэл шинээр энэ зүйлийг хийж эхэлснээс үл хамааран бүх улсын байнгын хэрэгцээ юм. Хүний чадавхыг бэхжүүлэх хэрэгцээг коллеж, их дээд сургуулиудын академик сургалтаар дамжуулан шийдэх боломжтой ч, мөн төрийн, төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллага зэргээр дамжуулан бэхжүүлж болно. Бүх төрлийн сургалт, чадавхыг бэхжүүлэхэд олон нийт, бүлгүүд болон хувь хүмүүсийн СББӨ-ийн хамгаалалт, менежментэд өргөнөөр оролцох ач холбогдолтой юм.(15-р зүйл)</p>	

Түлхүүр үг	<ul style="list-style-type: none"> ● Багтаах/Оролцуулах ● Сургалт ● ТББ/Олон нийтийн байгууллагууд ● Чадавхийг бэхжүүлэх ● Дээд боловсрол
-------------------	--

Хяналт-шинжилгээ хийх, үе үе тайлагнах тухай тусгай заавар

Хяналтын ашиг тус	<p>Сургалтын хөтөлбөр, байгууллагуудын талаар дүн шинжилгээ хийх нь тухайн газарт СББӨ-ийн менежменттэй холбоотой чадавхыг бэхжүүлэх хэрэгцээт цар хүрээг тогтоож өгөхөд тусална. Энэ нь одоо яг ямар хэрэгцээ шаардлагатай зүйл тулгарч байгааг үнэлж, дунд болон урт хугацаанд шийдвэрлэх шаардлагатай асуудал дутагдлыг тодорхойлж, улс өөрийн боловсон хүчинд зохих түвшний сургалт болон бусад боломжийг олгох нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p>Дэлхийн түвшинд хяналт-шинжилгээ, тайлагнах нь олон улсын хамтын ажиллагааны боломжуудыг тодотгож, боловсон хүчин бусад гадаадын улс орноос сургалтын боломжуудыг эдэлж болох ба ЮНЕСКО-гийн харьяа түншүүд, байгууллагуудтай хамтран дэлхийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрөөр дамжуулан сургалтын дутагдлыг тодорхойлж шийдвэрлэх боломжтой.</p>
Мэдээллийн эх сурвалж	<p>БСШУЯ нь СББӨ-ийн чиглэлээр эрдмийн зэрэг, гэрчилгээ зэргийг олгохыг хариуцаж энэ чиглэлийн хөтөлбөр хаана хэрэгжиж байгаа мэдээллийг тогтоох. (Үнэлгээний хүчин зүйл 2.1). Хэрэв улс нь зөвлөлдөх эсвэл хамтын ажиллагааны механизмтай бол (Үзүүлэлт-1-г хар), төрийн байгууллагууд (Үнэлгээний хүчин зүйл 2.2) эсвэл төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс санал болгож буй сургалтын боломжуудын талаар мэдээлэл цуглуулж, түгээх. (Үнэлгээний хүчин зүйл 2.3)</p> <p>Эх сурвалжууд</p> <ul style="list-style-type: none"> ● Боловсролын яамны бүртгэл, мэдээлэл ● Коллеж, их сургуулийн хөтөлбөр, цахим сайт ● Соёлын яам эсвэл СББӨ хариуцсан бусад агентлагийн чадавхийг бэхжүүлэх стратеги ● Зориулалтын сургалтын байгууллага ● СББӨ-н чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын цахим сайт ● Хурал, семинар хэлэлцүүлгийн зарлал ба бусад боломжууд ● Уг сэдвээр мэдээллийн хэрэгслээр мэдээллэсэн зөвөлгөөн, сургалтын үйл ажиллагаа ● Чадавхийг бэхжүүлэх төслүүдийн талаарх ЮНЕСКО-гийн цахим хуудас